



**НИЙСЛЭЛИЙН НИЙГМИЙН
ХАМГААЛЛЫН ТУСГАЙ ТӨВИЙН
ЗАХИРЛЫН ТУШААЛ**

2017 оны 12 сарын 08 өдөр

Дугаар А/23

Улаанбаатар хот

**Хөдөлмөрийн дотоод журамд нэмэлт
өөрчлөлт оруулах тухай**

Монгол улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэр, түүний удирдлагын тухай хуулийн 33 дугаар зүйлийн 33.5, Хөдөлмөрийн тухай хуулийн 130 дугаар зүйл, Монгол Улсын Засгийн Газрын 2017 оны "Журам шинэчлэн батлах тухай" 89 дүгээр тогтоолын 3 дахь заалт, Нийслэлийн Засаг даргын 2017 оны "Журам батлах тухай" А/335 дугаар захирамж, Төвийн дүрмийн 6.3, 6.9, Хөдөлмөрийн дотоод журмын 1.5 дахь заалтыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

- 1.Төвийн "Хөдөлмөрийн дотоод журам"-ын 5.3, 5.4, 17.1 дэх заалтыг дор дурдсанаар шинэчлэн боловсруулж, 5.5, 10.9, 17.2 дахь заалтыг нэмж оруулсугай.
- 2.Төвийн "Хөдөлмөрийн дотоод журам"-ын нэмэлт өөрчлөлтийг хавсралтаар баталсугай.
- 3.Хөдөлмөрийн дотоод журмыг мөрдөж ажиллахыг нийт албан хаагчдад, хэрэгжилтэнд хяналт тавин ажиллахыг даргын дэргэдэх зөвлөл / Н.Нэргүй/-д үүрэг болгосугай.

ДАРГА  ЦЭРӨНДУЛАМ



318060218

Нийгмийн хамгааллын тусгай төвийн даргын
2017 оны 12 сарын 27-ны тушаалын хавсралт



5.3. Ажилтнууд улирал бүрийн сүүлийн сарын 25-ны дотор ажлын төлөвлөгөөний биелэлт, дараа улирлын төлөвлөгөөг ахлах арга зүйчид цахим болон цаасан суурьтайгаар өгсөн байна.

5.4. Ахлах арга зүйч ажилтнуудын тайланг уншиж, явцын хяналтын үнэлгээ, олон нийтийн ажлын оролцоо, шинээр санаачлан хийсэн ажил үйлчилгээ, хувь хүний манлайлал, албан хэрэг хөтлөлт, edoc, smartcity програмын ашиглалт, өөрийгөө хөгжүүлсэн байдлыг харгалзан улирал бүр үнэлгээ хийж, Даргын дэргэдэх Зөвлөлөөр хэлэлцүүлэн, үнэлгээг харгалзан авч хэрэгжүүлэх арга хэмжээг тодорхойлно.

5.5. Тайлан мэдээг нэгтгэх, мэдээлэхдээ Нийслэлийн Засаг даргын 2017 оны А/335 дугаар захирамжийг мөрдөн ажиллана.

10.9. Ажилтан нь бодлогын баримт бичиг, хууль тогтоомж, тогтоол шийдвэрийн хэрэгжилт, байгууллагын үйл ажиллагааны тайланг тогтоосон хугацаанд үнэн зөв, бодитой гаргаж өгөх үүрэгтэй.

17.1. Тэв нь өөрийн хариуцсан асуудлын хүрээнд хуульд заасан чиг үүргийг хэрэгжүүлсэн байдалд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх үүрэг бүхий нэгж, эсхүл ажилтантай байна.

17.2. Хяналт-шинжилгээ, үнэлгээний ажилтан /нэгж/ нь Засгийн газрын 2017 оны 89 дүгээр тогтоолыг хэрэгжүүлж ажлын байрны тодорхойлолтыг баримтлан ажиллана.